



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А1508

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 38 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Өмнөд Чүнчон аймгийн Сосань хоттой хөдөө аж ахуй, газар тариалангийн шинэ техник, технологийг нэвтрүүлэх, газар тариалангийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, хамтран ажиллах санал солилцохоор 12 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд айлчлал хийхэд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 4,500,000 (Дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т үүрэг болгосугай.


4.Айлчлалын үр дүнг илтгэх хуудсаар аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг аймгийн Засаг даргын Зөвлөх (Д.Батбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20... оны  
11 дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1	Улаанбаатар-Сөүл Сөүл-Улаанбаатар 2 талын нислэгийн тийз	2	1875000	3750000
2	Бэлэг дурсгал	15 ш	750000	750000
	Нийт дүн			4500000

\_\_оОо\_\_